# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр | Дугаар А/370 | Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 5 дугаар баг Биеийн тамир спортын газрын "Б" заалны их засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлыг 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр "Эчо Дизайн" ХХК-тай гэрээ шууд байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Аймгийн Биеийн тамир спортын газрын "Б" заалны их засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлыг гэрээт хугацаанд чанартай гүйцэтгэн холбогдох актаар хүлээлгэн өгөхийг "Эчо Дизайн" ХХК (Г.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

3.Биеийн тамир спортын газрын "Б" заалны их засварын ажлын зураг төсөл боловсруулах явцад хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Гэрээнд заагдсан санхүүжилтийг 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010961